CENTRAL express

# СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 19 өдөр | Дугаар 35 | Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй
хэлцэл хийх тухай

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК ("**Компани**")-ийн 100 хувийн эзэмшлийн охин компани болох Сентрал Фүүдс ХХК-ийг сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох асуудлыг хэлэлцээд Компанийн тухай хуулийн 76.1.17, 92.1 дэх заалт, Компанийн дүрмийн 9.4.18 дах заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд болох Премиум Прожект ХХК-ийн барьсан Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 11-р хороо, Хонхорын нутаг дэвсгэрт байрлах 3,536,813,777 (гурван тэрбум таван зуун гучин зургаан сая найман зуун арван гурван мянга долоон зуун далан долоо) төгрөгийн үнэ бүхий 35/10 кВ-ын 2Х1,000 кВа-н 2 трансформатортай дэд станц ("**Дэд станц**")-ыг Хавсралт 1 дэх Дэд станц худалдах, худалдан авах гэрээнд заасан нөхцөлөөр Сентрал Фүүдс ХХК-д шилжүүлж авахыг зөвшөөрсүгэй.

2. Дэд станцыг Сентрал Фүүдс ХХК-ийн өмчлөл, эзэмшилд шилжүүлэх, Дэд станц худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой бүх харилцаанд гарын үсэг зурах эрхийг Сентрал Фүүдс ХХК-ийн Гүйцэтгэх захирал (Д.Жүгдэрнамжил)-д олгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн газрын захирал, Бизнес контроллер (Д.Будханд)-т үүрэг болгосугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана)

CENTRAL EXPRESS CVS JSC
СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК
УЛААНБААТАР ХОТ
9022010246 6165804 ШЖР0471

| | | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн |
|---|---|---|---|---|
| ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА: | А.ГАНХУЯГ | | | |
| ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД: | А.ГАНБОЛД | | | |
| | Г.БАТ-ЭРДЭНЭ | | | |
| | З.УЯНГА | | | |
| | Г.ЧИНЗОРИГ | | | |
| | Б.БАТ-ЭРДЭНЭ | | | |
| ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД: | Ө.ЭРДЭНЭЧИМЭГ | | | |
| | В.ГАНЗОРИГ | | | |
| | ГАРИ СТИВЕН БИОНДО | | | |
| Тогтоолын батлагдсан хувь: | | | | |